



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 103

Хараат

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн A/05 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийт нутгаар цас орж, өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч болзошгүй байгаатай холбогдуулан сумын хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 05-ний өдрөөс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан сумын хэмжээнд өвс, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлж ажиллахыг тамгын газрын дарга, санхүү албаны дарга нарт даалгасугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг тамгын газрын дарга, байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч бөгөөд онцгой комиссын орлогч дарга (Н.Батгэрэл)-д даалгасугай.



ЗАСАГ ДАРГА А.ЭРДЭНЭСАЙХАН

4824010004